



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/118

Цагаандэнж

Г Үнэлгээний хороо байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах мэргэжлийн эрх бүхий байгууллагыг шалгаруулах үнэлгээний хорооны ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ш.Жавхлантагс (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд: С.Хүрэлхуяг (Аймгийн Ерөнхий архитектор) өөртэй нь зөвшилцсөнөөр

М.Золзаяа (Сургалтын менежер)

А.Мандаахүү (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: М.Дүүриймаа (Сан хариуцсан нягтлан бодогч)

2. Тендерийн урилга, тендер хүлээн авах, нээх ажиллагааг олон лийтэд ил тод нээлттэй, шударга зохион байгуулж, үнэлгээний хорооноос гаргасан шийдвэрийг 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Сумын Засаг даргад танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Ш.Жавхлантагс)-д даалгасугай.

3. 2022 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн А/105 тоот захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА

Д.ЦЭВЭГДОРЖ



642201276

Захирамж 2022



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА**

Цагаан дэнж 6 дугаар баг, Эрдэнэцогт сум,
Баянхонгор аймаг, 64025

2022. 11. 22 № 11955

танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Баянхонгор аймаг Эрдэнэцогт сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хорооны шийдвэр, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг үндэслэн мэдэгдэх нь:

1. "ГОЛДЕН МЭП" ХХК нь Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө ажил 24,913,086 (Хорин дөрвөн сая есөн зуун арван гурван мянга наян зургаа) төгрөгөөр гүйцэтгэхээр үнийн санал болон холбогдох материал ирүүлсэн материалыг нэг бүрчлэн үнэлсэн үнэлгээний дүнгүүдийг үндэслэн энэхүү тендерт хамгийн сайн үнэлэгдсэн тендер гэж үзэж тус аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах эрх олгож байна.

2. Гэрээг гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 6-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна уу.

ДАРГА



Д.ЦЭВЭГДОРЖ